Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Эрүүл мэндийн яамны хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас тус байгууллагын 2024 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эмгэг судлалын үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Эмгэг судлалын үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Эмгэг судлалын үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/З дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 725,552.7 мянган төгрөгөөр буюу 34.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	502,981.0	968,366.9	465,385.9
Бараа материал	31,408.6	46,818.6	15,410.0
Үндсэн хөрөнгө	1,596,449.5	1,818,641.4	222,191.9
Нийт хөрөнгө	2,130,839.1	2,856,391.8	725,552.7
Өглөг	-	28,927.4	28,927.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,130,839.1	2,827,464.4	696,625.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,130,839.1	2,856,391.8	725,552.7

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данснууд байна. Үүнд:

- Авлага дансны үлдэгдэл 968,366.9 мянган төгрөг болж 465,385.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд шинээр байгууллагаас авах 968,366.9 мянган төгрөгийн авлага бүртгэсэнтэй холбоотой;
- Бараа материал дансны үлдэгдэл 46,818.6 мянган төгрөг болж 15,410.0 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материалын худалдан авалтаас голлон нөлөөлсөн;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,818,641.4 мянган төгрөг болж, 222,191.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 473,446.9 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, тайлант онд 251,255.0 мянган төгрөгийн элэгдлийг нэмж байгуулсан нь нөлөөлсөн;
- Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ дансны үлдэгдэл 2,827,464.4 мянган төгрөг болж 696,625.3 мянган төгрөгийн тайлант үеийн үр дүнгээр нэмэгдсэн байна.



Эмгэг судлалын үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвийн 2024 оны төсвийн төсөлд улсын төсвийн санхүүжилтээр 3,059,693.0 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоор 700,000.0 мянган төгрөг, нийт 3,759,693.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, нийт зарлагыг санхүүжүүлэхээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт зардлыг 561,890.0 мянган төгрөгөөр бууруулж, 3,197,803.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Нийгмийн эрүүл мэнд хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны зардал, харуул, хамгаалалтын зардал, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,387,803.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 810,000.00 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,387,803.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 956,822.9 мянган төгрөг нийт 3,344,625.9 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, төсвийн зарцуулаагүй үлдэгдэл 202,702.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,141,923.9 мянган төгрөг буюу 98.3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 44,501.5 мянган төгрөг, харуул, хамгаалалтын зардлын төсвийг 80.1 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардлыг 11,297.6 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	71601-Нийгмийн эрүүл мэнд	3,197,803.0	3,141,923.8	55,879.2	98.3
2	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	3,102,986.0	3,058,484.5	44,501.5	98.6
3	80219- Харуул, хамгаалалтын зардал	19,254.1	19,174.0	80.1	99.6
4	80802: Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	75,562.9	64,265.3	11,297.6	85.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 109,336.1 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 509,639.3 мянган төгрөг нийт 618,975.4 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна. Үүнээс резидент эмч нарын цалин, нийгмийн даатгалын шимтгэлд 106,238.3 мянган төгрөг, бараа, үйлчилгээний зардалд 400,743.5 мянган төгрөг, нийт 506,982.1 мянган төгрөгийг зарцуулж, 111,993.6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлснийг авлагаар бүртгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд 850,089.4 мянган төгрөгийн 3 арга хэмжээг нээлттэй тендер сонгон шалгаруулалтаар, 290,022.4 мянган төгрөгийн 22 арга хэмжээг шууд худалдан авахаар, нийт 1,140,111.8 мянган төгрөгийн худалдан авах ажлын төлөвлөгөө баталсан байна. Гүйцэтгэлээр 850,500.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй бараа худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулж, 289,611.8 мянган төгрөгийн бараа, үйлчилгээг шууд худалдан авалт хийж, тайланг гаргасан байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Эмгэг судлалын үндэсний төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн үйл ажиллагааг сайжруулах, мөнгөн хөрөнгө, бараа материалын зарцуулалт, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоолгохтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Эс Жи Эм Ди-Аудит ХХК-ийн ахлах аудитор Д.Насанжаргал, аудитор О.Алтанцэцэг нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер Б.Оюунцэцэг, захирал Д.Эхбаяр нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүү, нийцлийн аудитын газрын аудитор М.Пагамдулам, аудитын менежер В.Эрдэнэцогт, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг хэрэгжүүлсэн.

Эмгэг судлалын үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний Аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 34 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, 1.5 хувиар буюу 49,652.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага тендер болон цахим худалдан авалтаас хамгийн бага үнийн дүнтэй болон чанар ба үнэлгээний аргыг ашиглан хамгийн бага харьцуулах үнэтэй болон загвар дээжийг туршиж сонгон шалгаруулалт хийх, цахим дэлгүүрээс худалдан авалт хийх зэргийг сонгон ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн судалгаагаар орон нутагт томиллоор ажиллахдаа хувийн хэвшлийн болон төрийн өмчийн аж ахуйн нэгжийн тээврийн хэрэгслээр үйлчлүүлээгүй, тэтгэвэрт гарахад олгосон нэг удаагийн мөнгөн

тэтгэмжийг бусад тэтгэмжтэй давхардуулан олгоогүй, цахим дэлгүүрээс 8,840.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 478,543.6 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

1.Тайлант онд шинэчлэгдсэн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг шилэн дансанд мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2,262,096.5 мянган төгрөгийн 17 гүйлгээ, зарлагын 474,148.6 мянган төгрөгийн 4 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 "Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна", 3.1.1 "төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд", 6 дугаар зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заалттай нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж ажиллах, зөвлөмж өгсөн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн хэмнэлтийн тухай хууль, тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ. Үүнд:

1.Тайлант хугацаанд байгууллагын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй Шинэ хоршоо төслийн хүрээнд 2 ажилтанд орон нутагт ажиллах томилолтын зардалд 4,395.0 мянган төгрөгийг олгож, томилолтын зардалд бүртгэн тайлагнасан, томилолтын анхан шатны баримтын бүрдэл дутуу байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6 "үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заалттай нийцээгүй.

Эмгэг судлалын үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны хууль, тогтоомж болон Төрийн хэмнэлтийн хуулийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2024 оны хагас жилийн санхүүгийн тайланг хамруулж, дансны авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, нэмэлт орлого дансны хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд нийт 512,230.2 мянган төгрөгийн 8 асуудлыг илрүүлж, асуудлын бүртгэлээр зөвлөмж өгсөн ба жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 507,835.2 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг залруулсан байна. Биелэлт хангалтгүй 4,395.0 мянган төгрөгийн 1 зөрчлийг тайлант оны аудитын тайланд тусгасан болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 168,539.1 мянган төгрөгийн 5 албан шаардлага, 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	5	168,539.1	5	168,539.1	100
Зөвлөмж	2	-	2	-	100
Нийт дүн	7	168,539.1	7	168,539.1	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрүүл Мэндийн яамны МОН/2023/10/30 төслийн хүрээнд Эмгэг судлалын Үндэсний төвд он дамжин нийлүүлэх тоног төхөөрөмжийг бүрэн хүлээн авч, тайлан тэнцэлд тусгасан эсэхийг анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 14,776.2 мянган төгрөгийн 4 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа:

- Харилцагчтай байгуулсан гэрээний дагуу HOSPITAL цахим системийн үйлчилгээний 2025 оны 6 дугаар сар хүртэлх хугацааны төлбөрт 6,600.0 мянган төгрөг төлөөд урьдчилж төлсөн зардлаар бүртгээгүй;
- Харилцагчтай байгуулсан гэрээний дагуу 2025, 2026, 2027 онуудын Менежментийн баталгаажуулалтын хяналтын төлбөрт 4,125.0 мянган төгрөг төлөөд урьдчилж төлсөн зардлаар бүртгээгүй;
- Тээврийн хэрэгслийн даатгалд 546.9 мянган төгрөгийг шилжүүлж, дараа онд хамаарах төлбөрийг урьдчилж төлсөн зардлаар бүртгээгүй;
- Тайлант оны цалингийн хүн амын орлогын албан татварын суутгалын тооцооллыг буруу хийж 3,504.3 мянган төгрөгийн татварын авлага дутуу бүртгэсэн;

Аудитаар нийт 144,336.7 мянган төгрөгийн 10 зөрчил² илэрснээс, НДС-нд төвлөрүүлэх 28,927.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 107,537.0 мянган төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлж, 7,872.3 мянган төгрөгийн 5 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 144,336.7 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 94,683.9 мянган төгрөгөөр давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Тайлант онд ажилчдад олгосон урамшууллаас 28,927.4 мянган төгрөгийн НДС, ЭМД-ын шимтгэлийг суутгаагүй байгаа нь Нийгмийн даатгалын Ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 "Даатгуулагч, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнд дараах цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг хамааруулна", 19.1.3 "ажил олгогчоос даатгуулагчид мөнгөн хэлбэрээр олгосон хоол, унаа, түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт, орон сууцны ашиглалтын төлбөр, тэдгээртэй адилтгах бусад орлого, сар, улирал, жилийн ажлын үр дүнг харгалзан олгосон шагнал, урамшуулал" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын санд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Албан шаардлага

1. Тайлант онд 14,311.0 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Эмгэг судлалын үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Жилийн эцэст авлагын үлдэгдлийг харилцагч байгууллагатай тооцоо нийлж, актаар баталгаажуулж, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

2. Тайлант хугацаанд 92,338.9 мянган төгрөгийн бараа материалын зарлагын гүйлгээг бүртгэхдээ шаардах хуудсанд байгууллагын дарга зөвшөөрч гарын үсэг зурдаггүй, шаардах хуудас дээр бичигдсэн тоо засвартай, зарим бараа материалын зарлагын шаардах хуудас бичээгүй, зөвхөн зарлагын баримт хөтөлсөн зэрэг бүртгэлээр тавих хяналт сул байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6 "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцээгүй, нийцсэн ба зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг үнэн зөв үйлдэж, бараа материалын зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, албан шаардлага хүргүүлэх.

3. Үндсэн үйл ажиллагааны орлогыг анх 550,000.0 мянган төгрөгөөр төлөвлөж, тодотголоор 47.2 хувь буюу 260,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 1,386,664.2 мянган төгрөгийн орлого орж төлөвлөгөөг 58.4 хувиар буюу 576,664.2 мянган төгрөгөөр давуулан биелүүлжээ. Сангийн сайдын 2024 оны 224 дугаар тушаалаар давсан орлогоос зарцуулах эрх олгосны дагуу 429,841.3 мянган төгрөг буюу 74.5 хувийг ажилчид урамшуулал олгох болон бусад зүйлд зарцуулсан байна. Орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөөгүйгээс, давсан орлого бүрдүүлж зарцуулж байгаа нь төсвийн хэмнэлтийн талаар хэрэгжүүлж байгаа бодлого чиглэлтэй нийцэхгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 16 дугаар зүйлийн 16.5.4 "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх" гэж заасантай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөн, төсвийн хэмнэлтийг хэрэгжүүлж ажиллах, албан шаардлага хүргүүлэх.

4. Тайлант онд 48,676.0 мянган төгрөгийн слайд хадгалах шүүгээ болон 44,550.0 мянган төгрөгийн процессор, өнгөт принтер, сервер компьютерыг сонгон шалгаруулалтгүй шууд худалдан авсан. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" заалт, Засгийн газрын 2024.01.03-ны 2 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагаанд босго үнийн дээд хязгаарыг мөрдөж сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, албан шаардлага хүргүүлэх.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлийн тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 заасан бүрэлдэхүүний дагуу гаргаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1 "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна", 54.5.1 "тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр/", 54.5.2 "татварын зарлагыг хуулийн этгээд, салбар бүрээр, холбогдох эрх зүйн үндэслэлийн хамт", 54.5.3 "тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл", 54.5.4 "хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/", 54.5.5 "нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуульд заасан бүрэлдэхүүний дагуу гаргах.

2. Мөнгөн хөрөнгийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нэр бүхий ажилтанд гадаадад сургалтад хамрагдахад 1,221.7 мянган төгрөгийг олгосон нь байгууллагын даргын тушаал шийдвэргүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримын бүрдэл дутуу ажил гүйлгээг хийхгүй байх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

3. Мөнгөн хөрөнгийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Харилцагч байгууллагад гэрээний дагуу Чанарын гадаад хяналтын төлбөрт 6,500,000 төгрөгийг шилжүүлсэн, гэрээг дүгнэн акт үйлдээгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу байхад зардалд бүртгэж тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримын бүрдэл дутуу байхад зардал гаргахгүй байх, цахим систем нэвтрүүлэн, хяналтын механизм бий болгох.

4. Бараа материалын зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хувь хүнээс худалдаж авсан (нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар) 150.6 мянган төгрөгийн бичиг хэргийн материалыг орлогод аваагүй шууд зардал бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн ба зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бараа материалыг орлогот авч, зарцуулалтад эрх бүхий албан тушаалтан хяналт тавьж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

5. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй 50,998.2 мянган төгрөгийн 15 ширхэг хөрөнгийн цаашид ашиглах хугацаа, шинэчлэн тогтоох үнийг боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" НББ-ийн тухай хуулийн 5.1.5 "хэмжигдэхүйц байх", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дугаар тушаалын 7.1 "Элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох" гэж заасантай нийцэхгүй, ангилал ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн ашиглалт, өртөг нөхөлтөд хяналт тавьж, үнийг шинэчлэн тогтоох асуудлыг эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.